



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/34/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер Б.Сэржмядаг
Утас: 261885 Цахим хаяг: serjmyadag@audit.gov.mn
Аудитор Ж.Энхтуяа
Утас: 260512 Цахим хаяг: enkhtuyaj@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Баян суварга аудит" ХХК-ийн
захирал С.Должинсүрэн
Утас: 99126723 Цахим хаяг: doljinsuren9@yahoo.com

Улаанбаатар хот
2022 он

АГУУЛГА

2.	Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1.	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2.	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3.	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4.	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5.	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6.	Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	13
3.	Аудитын тайлан.....	14
3.1.	Ерөнхий зүйл.....	14
3.2.	Байгууллагын зорилго, түүний орчин ба дотоод хяналт.....	14
3.3.	Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4.	Материаллаг байдал.....	15
3.5.	Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6.	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.7.	Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8.	Аудитын гол асуудал.....	18
3.9.	Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
3.10	Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
3.11	Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
4.	Аудитын илрүүлэлт.....	20
4.1	Залруулсан алдаа.....	20
4.2	Албан шаардлага.....	20
4.3	Зөвлөмж.....	21
5.	Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТБОНӨХБААХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭЕШ	Элсэлтийн ерөнхий шалгалт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Баян тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

**БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ГАНБАТ ТАНАА**

2022-02-21 № 07/309
тасвай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгөлөмчийн өөрчлөлт, мөнгөн гүйцээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Боловсролын хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Y15_10.11.2018\chig_K\new\Yewlan_B\chig\2022\2214 Auditin 2 Газар\11.Docx

201050503

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн одийн зөслийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>413,895,612.13</u>	<u>481,578,611.99</u>
33	АВЛАГА	<u>271,369,473.79</u>	<u>313,664,897.94</u>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	7,706,895.00	32,142.00
33300	Татаас санхүүжилтийн авлага	247,260,841.70	312,423,695.94
335	Бусад авлага	16,401,737.09	1,209,060.00
3351	Байгууллагаас авах авлага	15,122,677.09	
3352	Хувь хүнээс авах авлага	1,279,060.00	1,209,060.00
35	БАРАА МАТЕРИАЛ	<u>142,526,138.34</u>	<u>167,913,714.05</u>
351	Түүхий эд материал	44,528,621.68	46,049,350.05
35110	Тусгай зориулалттай материал	44,348,621.68	45,694,350.00
35130	Эм боох материал	180,000.00	355,000.05
354	Хангамжийн материал	97,997,516.66	121,864,364.00
35410	Бичиг хэргийн материал	22,758,966.66	34,946,250.00
35420	Аж ахуйн материал	25,035,500.00	23,322,900.00
35440	Түлш, шатах тослох материал	3,843,950.00	1,960,705.00
35460	Хүнсний материал	-	30,100.00
35470	Бусад хангамжийн материал	46,359,100.00	61,604,409.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,289,011,069.85</u>	<u>1,750,828,134.67</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>1,289,011,069.85</u>	<u>1,750,828,134.67</u>
392	Биет хөрөнгө	<u>1,219,053,030.73</u>	<u>1,626,499,228.93</u>
39203	Авто-тээврийн хэрэгсэл	24,735,000.00	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	(7,447,916.63)	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,557,754,844.00	3,142,363,934.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,432,961,343.34)	(1,638,136,936.81)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	93,441,993.33	87,339,993.33
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,553,296.56)	(29,667,761.59)
39214	Бусад үндсэн хөрөнгө	52,884,840.00	51,815,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(42,441,097.07)	(47,215,500.00)
39217	Номын фонд		60,000,000.00
393	Биет бус хөрөнгө	<u>69,958,039.12</u>	<u>124,328,905.74</u>
39301	Програм хангамж	347,603,560.00	440,003,560.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(277,645,520.88)	(315,674,654.26)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,702,906,681.98</u>	<u>2,232,406,746.66</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>11,570,858.61</u>	<u>8,517,233.07</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	<u>11,570,858.61</u>	<u>8,517,233.07</u>
413	Өглөг	<u>11,570,858.61</u>	<u>8,517,233.07</u>
41310	Ажилчидтай холбоотой өглөг	2,812,578.61	3.82
4136	Бусад өглөг	<u>8,758,280.00</u>	<u>8,517,299.25</u>
41361	Байгууллагад төлөх өглөг	2,892,305.00	8,517,229.25
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	5,865,975.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,691,335,823.37</u>	<u>2,223,889,513.59</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>1,691,335,823.37</u>	<u>2,223,889,513.59</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	344,839,013.00	344,839,013.00
51101	Өмч: - төрийн	344,839,013.00	344,839,013.00
512	Хуримтлагдсан үр дүн	<u>1,346,496,810.37</u>	<u>1,879,050,500.59</u>
51210	Өмнөх үеийн үр дүн	2,471,886,573.99	1,346,496,810.37
51220	Тайлант үеийн үр дүн	(1,125,389,763.62)	532,553,690.22
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	-
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,702,906,681.98</u>	<u>2,232,406,746.66</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,507,485,661.79	5,466,836,000.54
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	628,018,949.79	1,578,840,887.54
120	Нийтлэг татварын бус орлого	628,018,949.79	1,578,840,887.54
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	627,510,528.11	1,573,378,078.54
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	603,135,528.11	752,320,078.54
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0,00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	24,375,000.00	821,058,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого БМ	508,421.88	5,462,809.00
122	Тусламжийн орлого	1,879,466,712.00	3,887,995,113.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,345,380,800.00	1,212,920,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,345,380,800.00	1,212,920,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	534,085,912.00	2,675,074,413.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	262,931,700.00	563,494,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	271,154,212.00	2,111,580,213.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,632,875,425.41	4,912,700,008.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,632,875,425.41	4,912,700,008.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,600,507,750.79	4,865,468,912.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,382,924,134.60	999,860,939.84
210101	Үндсэн цалин	542,864,905.00	406,429,649.80
210102	Нэмэгдэл	86,273.00	55,764,973.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0,00	22,170,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	839,972,956.60	515,496,316.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	175,828,649.54	128,972,765.04
210201	Тэтгэврийн даатгал	153,746,636.34	109,462,490.04
210202	Тэтгэмжийн даатгал	5,696,902.80	4,994,119.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,893,095.18	3,870,974.35
210204	Ажилгүйдлийн даатгал	1,092,340.36	967,743.65
210205	Эрүүл мэндийн даатгал	10,399,674.86	9,677,438.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	138,722,400.00	138,722,400.00
210304	Байрны түрээс	138,722,400.00	138,722,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	69,415,778.60	22,559,257.01
210401	Бичиг хэрэг	33,168,650.00	13,113,670.00
210402	Тээвэр, шатахуун	9,838,650.00	3,769,195.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,416,528.60	4,206,592.01
210404	Ном, хэвлэл	14,000,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,991,950.00	1,469,800.00
2105	Нормативт зардал	51,418,000.00	1,846,440.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	51,418,000.00	1,846,440.00
2107	Томилолт, зочны зардал	82,932,600.00	1,300,000.00
210701	Гадаад албан томилолт	38,166,000.00	-
210702	Дотоод албан томилолт	44,766,600.00	1,300,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	113,922,734.00	143,847,218.79
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,042,164.00	81,427,950.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		4,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,416,920.00	-

Боловсролын үнэлгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	252,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,669,400.00	1,645,318.79
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	94,542,250.00	56,773,950.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,585,343,454.05	3,428,359,892.22
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал	1,057,006,163.67	2,931,801,637.33
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	528,337,290.38	496,558,254.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,367,674.62	47,231,095.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	32,367,674.62	47,231,095.45
213303	Урсгал үйл ажиллагааны санхүүжилтээс төвлөрүүлэх шилжүүлэг	32,367,674.62	47,231,095.45
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(1,125,389,763.62)	554,135,992.19
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)		21,582,301.97
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		21,073,880.29
225011	Дамжуулан зээлдүүлэх зээл		508,421.68
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)		(21,582,301.97)
7	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(1,125,389,763.62)	532,553,690.22

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	344,839,013.00	158,184.43	2,471,728,389.56	2,816,725,586.99
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			158,184.43	158,184.43
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	344,839,013.00	158,184.43	2,471,886,573.99	2,816,883,771.42
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		(158,184.43)		(158,184.43)
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн				
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	344.839.013.00	-	1,346,496,810,37	1,691,335,823.37
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	344.839.013.00	-	1,346,496,810,37	1,691,335,823.37
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Тайлант үеийн үр дүн			532,553,690.22	532,553,690.22
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	344.839.013.00	-	1,879,050,500.59	2,223,889,513.59

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>3,610,170,389.04</u>	<u>4,887,646,033.24</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	607,484,153.11	752,390,078.54
120	Нийтлэг татварын бус орлого	607,484,153.11	752,390,078.54
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	607,484,153.11	752,390,078.54
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	607,484,153.11	752,390,078.54
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,002,686,253.93	4,135,255,954.70
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,345,380,800.00	1,212,920,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,345,380,800.00	1,212,920,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,657,305,435.93	2,922,335,254.70
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	262,931,700.00	563,494,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,394,373,735.93	2,358,841,054.70
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>3,400,776,389.04</u>	<u>4,729,254,833.24</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,400,776,389.04	4,729,254,833.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,121,147,872.72	4,369,600,041.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,392,156,028.69	972,144,686.29
210101	Үндсэн цалин	356,932,700.00	315,922,422.64
210102	Нэмэгдэл	115,015,900.00	117,301,416.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	57,090,416.07	53,443,173.30
210104	Урамшуулал	314,483.93	342,841.00
210105	Гэрээт ажлын хөлс	862,802,528.69	485,134,832.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	171,976,561.54	128,172,134.04
210201	Тэтгэврийн даатгал	157,065,161.54	109,107,751.20
210202	Тэтгэмжийн даатгал	3,727,900.00	4,902,900.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,982,300.00	3,895,620.39
210204	Ажилгүйдлийн даатгал	745,600.00	890,166.19
210205	Эрүүл мэндийн даатгал	7,455,600.00	9,375,695.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	138,722,400.00	138,722,400.00
210304	Байрны түрээс	138,722,400.00	138,722,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	47,467,778.60	35,001,702.01
210401	Бичиг хэрэг	13,179,950.00	11,378,860.00
210402	Тээвэр, шатахуун	7,704,100.00	5,219,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,416,528.60	4,206,592.01
210404	Ном, хэвлэл	14,000,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,167,200.00	14,196,400.00
2105	Нормативт зардал	51,598,000.00	1,846,440.00
210503	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	51,598,000.00	1,846,440.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,277,000.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,210,000.00	-
210602	Тавилга	1,067,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	82,932,600.00	1,300,000.00
210701	Гадаад албан томилолт	38,166,000.00	-
210702	Дотоод албан томилолт	44,766,600.00	1,300,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	146,559,921.65	146,415,068.79

Боловсролын үнэлгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,679,351.35	81,812,950.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		4,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,416,920.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	252,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,669,400.00	1,645,318.79
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	112,542,250.00	58,956,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,084,457,582.24	2,945,997,610.72
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал	1,084,457,582.24	2,945,997,610.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	279,628,516.32	359,654,791.39
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	279,628,516.32	359,654,791.39
213303	Урсгал үйл ажиллагааны санхүүжилтээс төвлөрүүлэг шилжүүлэг	32,367,674.62	47,231,095.45
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг	247,260,841.70	312,423,695.94
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>209,394,000.00</u>	<u>158,391,200.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	209,394,000.00	158,391,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	209,394,000.00	158,391,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	209,394,000.00	158,391,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	209,394,000.00	158,391,200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(209,394,000.00)</u>	<u>(158,391,200.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,964,920,700.00	1,921,528,789.09	43,391,910.91	97.8
УРСГАЛ ЗАРДАЛ	1,964,920,700.00	1,921,528,789.09	43,391,910.91	97.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,964,527,100.00	1,921,528,789.09	42,998,310.91	97.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	501,695,100.00	487,009,853.79	14,685,246.21	97.1
Үндсэн цалин	329,274,300.00	315,922,422.64	13,351,877.36	95.9
Нэмэгдэл	115,015,900.00	117,301,416.85	(2,285,516.85)	102.0
Унаа хоолны хөнгөлөлт	56,404,900.00	53,443,173.30	2,961,726.70	94.7
Урамшуулал	1,000,000.00	342,841.00	657,159.00	34.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,728,900.00	64,665,072.00	3,063,828.00	95.5
Тэтгэврийн даатгал	47,661,000.00	45,600,689.16	2,060,310.84	95.7
Тэтгэмжийн даатгал	5,017,000.00	4,902,900.55	114,099.45	97.7
ҮОМШӨ-ний даатгал	4,013,600.00	3,895,620.39	117,979.61	97.1
Ажилгүйдлийн даатгал	1,003,400.00	890,166.19	113,233.81	88.7
Эрүүл мэндийн даатгал	10,033,900.00	9,375,695.71	658,204.29	93.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,800,000.00	91,800,000.00	-	100.0
Байрны түрээс	91,800,000.00	91,800,000.00	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	24,753,700.00	21,382,702.01	3,370,997.99	86.4
Бичиг хэрэг	7,560,800.00	7,559,860.00	940.00	100.0
Тээвэр, шатахуун	5,222,300.00	5,219,850.00	2,450.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,629,200.00	4,206,592.01	2,422,607.99	63.5
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал				
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,341,400.00	4,396,400.00	945,000.00	82.3
Нормативт зардал	1,846,900.00	1,846,440.00	460.00	100.0
Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	1,846,900.00	1,846,440.00	460.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	-	-	-	-
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-	-	-
Урсгал засвар	-	-	-	-
Томилолт, зочны зардал	17,696,800.00	1,300,000.00	16,396,800.00	7.3
Дотоод албан томилолт	17,696,800.00	1,300,000.00	16,396,800.00	7.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	177,418,800.00	174,415,068.79	3,003,731.21	98.3
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	109,863,000.00	109,812,950.00	50,050.00	100.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	4,000,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	2,145,000.00	-	2,145,000.00	-
Тээврийн хэрэгслийн татвар	237,200.00	-	237,200.00	-
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,057,000.00	1,645,318.79	411,681.21	80.0

Боловсролын үнэлгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	59,116,600.00	58,956,800.00	159,800.00	99.8
Бараа үйлчилгээний бусад зардал	1,081,586,900.00	1,079,109,652.50	2,477,247.50	99.8
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,081,586,900.00	1,079,109,652.50	2,477,247.50	99.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	393,600.00	-	393,600.00	-
Бусад урсгал шилжүүлэг	393,600.00	-	393,600.00	-
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	393,600.00	-	393,600.00	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,964,920,700.00	1,921,528,789.09	43,391,910.91	97.8
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,212,920,700.00	1,169,138,710.55	43,781,989.45	96.4
Улсын төсвөөс санхүүжих	1,212,920,700.00	1,169,138,710.55	43,781,989.45	96.4
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	752,000,000.00	752,390,078.54	(390,078.54)	100.1
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	752,000,000.00	752,390,078.54	(390,078.54)	100.1
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	-
Төсвийн байгууллага	1	1	-	-
АЖИЛЛАГСАДЫН ТОО	38	35	-	92.1
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	37	34	-	91.9
Үйлчлэх ажилтан	-	-	-	-
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	38	35	-	92.1
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	38	35	-	92.1

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

			<i>/төгрөгөөр/</i>
	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		2,922,335,254.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,922,335,254.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,606,462,452.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал		485,134,832.50
210105	Гэрээт ажлын хөлс		485,134,832.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		63,507,062.04
210201	Тэтгэврийн даатгал		63,507,062.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		46,922,400.00
210304	Байрны түрээс		46,922,400.00
2104	Хангамж бараа материалын зардал		13,619,000.00
210401	Бичиг хэрэг		3,819,000.00
210406	Бага, үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		9,800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж		32,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж		32,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,965,279,158.22
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал		1,965,279,158.22
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		315,872,801.94
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		3,449,106.00
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг		312,423,695.94
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		2,922,335,254.70
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		2,922,335,254.70
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		563,494,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,358,841,054.70
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Боловсролын үнэлгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагахолбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад мөнгөн хөрөнгийн данс, худалдан авалт, шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян суварга Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Юра, аудитор Н.Бат-Оюун нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Мөнхзул, захирал С.Должинсүрэн нар тус тус хэрэгжүүлсэн.

Боловсролын үнэлгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/30 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Боловсролын үнэлгээний төв нь сурлагын амжилт, бүх шатны боловсролын сургалтын чанарт хяналт-шинжилгээ, үнэлгээ судалгаа хийх, сургалт зохион байгуулах, их дээд сургууль, коллежид элсэгчдээс авах ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын мэдлэг, чадварын түвшинг тогтоох зорилго бүхий элсэлтийн ерөнхий шалгалтыг үндэсний түвшинд зохион байгуулах чиг үүрэг бүхий байгууллага юм.

Дээрх зорилтын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бүх шатны сургалтын байгууллагын сургалтын чанарыг үнэлэх шалгуур үзүүлэлтийг олон улсын жишиг арга зүй, аргачлалаар боловсруулах, чанарын хяналт-шинжилгээ хийх, санал, дүгнэлт гаргах;
- Шалгуулагчдын дүн оноо ил тод, нээлттэй, шударга, шуурхай болох боломжийг бүрдүүлж, нийгэм, эдийн засгийн бодит үр дүнг бий болгох;
- Улсын шалгалтын жишиг даалгавар боловсруулж, сургуулиуд өөрсдийн хөтөлбөрт нийцүүлэн даалгавараа сонгодог, нууцлалаа хангадаг тогтолцоог бий болгох.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найрууллага/
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаал “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”;

- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/22 дугаар тушаал “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” (БШУС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдөгдөх)

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Боловсролын үнэлгээний төвийн захирлын 2021 оны А/120 тушаалаар тус төвийн Дотоод хяналт шалгалтын журмыг батлан мөрдүүлж, тайлант онд хяналт шалгалтыг 11 асуудлаар төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Боловсролын үнэлгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн, үнэн зөв бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 3,632,875.4 мянган төгрөгөөс хувиар буюу 36,328.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Материаллаг байдлын зөрүү өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс 26.0 хувиар өссөн тул гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт 4,912,700.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 49,127.0 мянган төгрөгөөр тогтоов.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Боловсролын үнэлгээний төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 529,500.0 мянган төгрөгөөр буюу 131.1 хувиар өсч, материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	271,369.5	313,664.9	42,295.4
Урьдчилгаа (урьдчилж гарсан зарал)	-	-	-
Бараа материал	142,526.1	167,913.7	25,387.6
Үндсэн хөрөнгө	1,289,011.1	1,750,828.1	461,817.0
Нийт хөрөнгө	1,702,906.7	2,232,406.7	529,500.0
Өр төлбөр	11,570.9	8,517.2	(3,053.6)
Засгийн газрын хувь оролцоо	1,691,335.8	2,223,889.5	(532,553.7)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө/ өмчийн дүн	1,702,906.7	2,232,406.7	(529,500.0)

Авлага дансны үлдэгдэл 313,664.9 мянган төгрөг болж 42,295.4 мянган төгрөгөөр өссөн нь татаас санхүүжилтийн авлагаас шалтгаалжээ.

Дэлхийн банкны санхүүжилтээр “Боловсролын чанарын шинэчлэл төсөл”-ийн хүрээнд СТ-1.17 дугаар гэрээгээр “Олон улсын сургалтын амжилтыг үнэлэх / PISA-2022/ төсөл”-ийг 2019-2023 онуудад хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу 2019-2021 онуудад нэмэлт санхүүжилтийн 100900015430 дугаар дансанд нийт 1,894,891.8 мянган төгрөгийн орлого хүлээн авсанаас гүйцэтгэлээр 1,582,468.1 мянган төгрөгийн зардал гарч, зарцуулаагүй үлдсэн үлдэгдэл 312,423.7 мянган төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлснийг тайлант оны эцэст татаас санхүүжилтийн авлагаар бүртгэж тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 167,913.7 мянган төгрөг болж 25,387.6 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын болон бичиг хэрэг, хангамжийн материал бэлтгэснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,750,828.1 мянган төгрөг болж 461,817.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 60,000.0 мянган төгрөгийн номын фонд, 46,400.0 мянган төгрөгөөр програм хангамж, нэмэлт төсвийн хөрөнгөөр 5,991.2 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж, 46,000.0 мянган төгрөгийн програм хангамж худалдан авч, 821,058.0 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй шилжиж ирсэн, 75,911.1 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан, 24,375.0 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлсэн, тайлант онд 496,558.3 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан нь шалтгаалжээ.

Тайлант онд ТӨБЗГ-ын А-1/857 дугаар албан бичгээр 24,375.0 мянган төгрөгийн балансын үнэтэй, 9,479.2 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл, 14,895.8 мянган төгрөгийн үлдэх өртөг бүхий FJ Крузер маркын автомашиныг Шинжлэх ухаан, технологийн сургуульд балансаас балансад шилжүүлж, ТӨБЗГ-ын А-1/918 дугаар албан бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу 37 нэрийн 75,911.1 мянган төгрөгийн анхны өртөг бүхий үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Биет бус хөрөнгийн дансны үлдэгдэл 124,328.9 мянган төгрөг болж 54,370.8 мянган төгрөгөөр өссөн нь сервер, шалгалтын өгөгдөлийн сангийн архив үүсгэх, И-баримт илгээх програм, ЭЕШ-ын аппликейшн, даалгаврын сангийн програм хөгжүүлэлт зэргийг худалдан авсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 8,517.2 мянган төгрөг болж 3,053.6 мянган төгрөгөөр буурсан нь НДШ, ХХОАТ-ын өр төлбөрийг барагдуулсанаас шалтгаалжээ.

Боловсролын үнэлгээний төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2,959.350.3 мянган төгрөгөөр буюу 218.0 хувиар өссөн нь тайлант онд 821,058.0 мянган төгрөгийн тоног төхөөрмж, 5,462.8 мянган төгрөгийн хангамжийн материалыг хандив, тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлого 149,184.6 мянган төгрөгөөр өссөнөөс шалгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 1,279,824.5 мянган төгрөгөөр буюу 135.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал байна. Энэ нь элсэлтийн ерөнхий шалгалтыг жилд 2 удаа, оношлох үнэлгээний шалгалтыг анх удаа орон даяар тус тус зохион байгуулсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага 2021 оны төсвийн төслийг 3,066,647.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,101,726.6 мянган төгрөгөөр бууруулж 1,964,920.7 мянган төгрөгөөр баталсан байгаа нь төсвийн төлөвлөлтийг үндэслэлтэй төлөвлөөгүйг харуулж байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,964,920.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,212,920.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 752,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,212,920.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 752,390.1 мянган төгрөг, нийт 1,965,310.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,921,528.8 мянган төгрөгийг зарцуулж 43,782.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,921,528.8 мянган төгрөг буюу 97.8 хувьтай байгаа нь цалин хөлс 14,685.2 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 3,063.8 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 3,371.0 мянган төгрөгөөр, томилт, зочны зардлыг 16,396.8 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 3,003.7 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 2,477.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	7180 8	Боловсролын бодлого удирдлага	1,964,920.7	1,921,528.8	43.391,9	97.8
1.1	8010 1	Үндсэн үйл ажиллагааны зардал	1.964.527,1	1.921.528,8	42.998,3	97.8
1.2	8080 2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	393.6	-	393.6	-

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтын дансанд дээд шатны төсвийн захирагчаас 563,494.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,358,841.1 мянган төгрөг, нийт 2,922,335.3 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлжээ.

Үүнээс гэрээт ажлын цалинд 485,134.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 63,507.1 мянган төгрөг, байрны түрээсд 46,922.4 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 3,819.0 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлийн зардалд 9,800.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 32,000.0 мянган төгрөг, хичээл үйлдвэрийн дадлага хийх зардалд 1,965,279.1 мянган төгрөг зарцуулж, үлдэгдэл 315,872.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус төвөөс хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөр 2 арга хэмжээний хэрэгжилт 100 хувь, хөтөлбөр арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 97.8 хувийн биелэлттэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Боловсролын үнэлгээний төв нь тус төвийн захирлын 2014 оны А/168 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг завсрын аудитаар нягтлан бодох бүртгэлийн хууль, стандарт, дүрэм, журмын өөрчлөлттэй уялдуулан байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан шинэчлэн боловсруулах нь зүйтэй гэсэн зөвлөмж өгсөн.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг шинэчлэн баталж, 2021 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн БШУС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдүүлэхээр шийдвэрлэсэн боловч хэвлэлтийн үйл ажиллагаанаас шалтгаалан тайлант оны эцэст харьяа байгууллагуудад хүргүүлсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 9 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Боловсролын үнэлгээний төвийн 2021 онд нийт 13,317.7 сая төгрөгийн 334 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 91.0 сая төгрөгийн 5 мэдээллийг ил тод байршуулаагүй, 1,762.2 сая төгрөгийн 32 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмын хүрээнд зөвлөх үйлчилгээний 24,090.0 мянган төгрөгийн 1, харьцуулалтын аргаар 764,126. 8 мянган төгрөгийн 20, нээлттэй тендер шалгаруулалтын 96,195.0 мянган төгрөгийн 1, нийт 22 төрлийн худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.

"Элсэлтийн ерөнхий шалгалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" БШУС-ын 2021 оны А/238 дугаар тушаалаар 2021 оны 7 дугаар сард зохион байгуулагдах ЭЕШ-ыг 2021 оны 8 сард зохион байгуулах шийдвэр гарсны дагуу хойшлогдсоны улмаас харьцуулалтын аргаар зохион байгуулсан худалдан авалтын 3 тендер зарцуулсан нийт 143,362.8 мянган төгрөгийн үргүй зардал гарч, БШУЯ-ны нэмэлт санхүүжилтээр дахин 110,929.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.Үүнд:

- 2021 оны Элсэлтийн ерөнхий шалгалтын дэвтэр, хариултын хуудас, батламж хуудас, цаасан лац, гэрээний хуудасны санамж, явцын протокол, зөвлөмж хэвлэх тендер- 61,965.0 мянган төгрөг,
- 2021 оны ЭЕШ-ын бэлтгэл постны байр, хоол нийлүүлэх тендер- 32,392.8 мянган төгрөг,
- 2021 оны ЭЕШ-ын сэдвийн постны байр, хоол нийлүүлэх тендер- 49,005.0 мянган төгрөг.

Аудитаар ТБОНӨХБАҮХАТХ-ийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Бүтээгдэхүүн нийлүүлэх, үнийн санал авах баримт бичгийн шалгуур үзүүлэлтэд заасан шалгуур үзүүлэлтийг хангаагүй Перфект комфорт ХХК-ийг сонгон шалгаруулж 40,593.0 мянган төгрөгийн худалдан авалтын гэрээ байгуулсан.
- Тундас эрдэнэ ХХК-тай байгуулсан ариутгалын ажил гүйцэтгэх 6,710.0 мянган төгрөгийн шууд худалдан авалтын гэрээний ерөнхий зүйлд худалдан авалтын нэр, тоо хэмжээг тодорхой заагаагүйгээс гэрээний гүйцэтгэл хангалтгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн боловч зөрчил дахин давтагдан гарсан тул хариуцсан албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, худалдан авах ажиллагаа "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 312,464.5 мянган төгрөгийн 8 алдаа зөрчил илрүүлснээс 265,161.5 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 47,303.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмжийг өгсөн.

Өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад 4 зөвлөмжийг хэрэгжүүлж, 47,303.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд өгсөн зөвлөмжийг залруулах боломжгүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 акт, 2 албан шаардлага, 2 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт	1	14,803.2	1	14,803.2			
Албан шаардлага	2	27,276.7	2	27,276.7			
Зөвлөмж	2	14,400.0	2	14,400.0			
Нийт дүн	5	56,479.9	5	56,479.9			

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй "Олон улсын сургалтын амжилтыг үнэлэх /PISA-2022/ төсөл"-ийн хөрөнгийн зарцуулалт, төслийн хэрэгжилт, үр дүнг нарийвчлан авч үзэх.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 312,464.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 265,161.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 47,303.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 530.0 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг бүртгэсэн;
- Үндсэн хөрөнгийн дансанд бараа материалын шинжтэй 17 нэрийн нийт 173,700.4 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэж тайлагнасан;
- Ашиглалтын хэрэгцээ, шаардлага хангахгүй болсон 2 нэрийн нийт 15,020.0 мянган төгрөгийн түүхий эд бараа материалыг төвийн захирлын тушаал шийдвэргүйгээр устгаж зарлага болгосон;
- ТӨБЗГ-ын 2021 оны А-1/918 дугаар албан бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу 37 нэрийн 75,911.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан боловч Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэр гаргаж Устгалын акт үйлдээгүй.

4.2 Албан шаардлага

Боловсролын үнэлгээний төвийн 2021 онд нийт 13,317.7 сая төгрөгийн 334 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 91.0 сая төгрөгийн 5 мэдээллийг ил тод байршуулаагүй, 1,762.2 сая төгрөгийн 32 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн боловч зөрчил дахин давтагдан гарсан тул хариуцсан албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага өгөх.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус төв нь дараах 4 арилжааны банкуудад төгрөгийн харилцах данс эзэмшдэг бөгөөд тайлант онд гүйлгээ хийгдээгүй, үлдэгдэлгүй болохыг холбогдох банкуудаас баталгаа гаргуулж авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банкинд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Зөвшөөрөлгүйгээр нээсэн арилжааны банкуудад байршиж буй харилцах дансыг хаах.

Цаашид мөнгөн хөрөнгийн бүртгэл тайлан тооцоонд тавих дотоод хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
							Залруулга		Хариуцлага ногдуулах Албан шаардлага		Албан шаардлага		Зөвлөмж	
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар														
1	Боловсролын үнэлгээний төв	АХГ-2022/23/НА-СТА-ТШЗ	Тус төв нь дараах 4 арилжааны банкуудад төгрөгийн харилцах данс эзэмшдэг бөгөөд тайлант онд гүйлгээ хийгдээгүй, үлдэгдэлгүй болохыг холбогдох банкуудаас баталгаа гаргуулж авсан байна. Үүнд: -Голомт банкны төгрөгийн 1105038452 дугаар, -Хас банкны төгрөгийн 5002003536 дугаар, -Төрийн банкны төгрөгийн 100000381956 дугаар, -Худалдаа хөгжлийн банкны 490001103 дугаар	Зөвшөөрөлгүйгээр нээсэн арилжааны банкуудад байршиж буй харилцах дансыг хаах. Цаашид мөнгөн хөрөнгийн бүртгэл тайлан тооцоонд тавих дотоод хяналтыг сайжруулах.	1							1		
2	Боловсролын үнэлгээний төв	АХГ-2022/23/НА-СТА-ТШЗ	Бүтээгдэхүүн нийлүүлэх, үнийн санал авах баримт бичгийн шалгуур үзүүлэлтэд заасан шалгуур үзүүлэлтийг хангаагүй Перфект комфорт ХХК-ийг сонгон шалгаруулж 40,593.0 мянган төгрөгийн худалдан авалтын гэрээ байгуулсан. Тундас эрдэнэ ХХК-тай байгуулсан ариутгалын ажил гүйцэтгэх 6,710.0	Бүтээгдэхүүн нийлүүлэх, үнийн санал авах баримт бичгийн шалгуур үзүүлэлтийг хангасан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж ажиллах	2	47,303.0						2	47,303.0	

Боловсролын үнэлгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

			мянган төгрөгийн шууд худалдан авалтын гэрээний ерөнхий зүйлд худалдан авалтын нэр, тоо хэмжээг тодорхой заагаагүйгээс гэрээний гүйцэтгэл хангалтгүй байна.											
3	Боловсролын үнэлгээний төв	АХГ-2022/23/НА-СТА-ТШЗ	<p>Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 530.0 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг бүртгэсэн;</p> <p>Үндсэн хөрөнгийн дансанд бараа материалын шинжтэй 17 нэрийн нийт 173,700.4 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэж тайлагнасан;</p> <p>Ашиглалтын хэрэгцээ, шаардлага хангахгүй болсон 2 нэрийн нийт 15,020.0 мянган төгрөгийн түүхий эд бараа материалыг төвийн захирлын тушаал шийдвэргүйгээр устгаж зарлага болгосон;</p> <p>ТӨБЗГ-ын 2021 оны А-1/918 дугаар албан бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу 37 нэрийн 75,911.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан боловч Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэр гаргаж Устгалын акт үйлдээгүй.</p>	Аудитаар 174,230.4 мянган төгрөгийн хөрөнгийг холбогдох дансанд шилжүүлэн бүртгэж, данснаас хассан 90,931.1 мянган төгрөгийн хөрөнгөтэй холбоотой баримт материалыг бүрдүүлж албажуулсан.	4	265,161.5	4	265,161.5						

Боловсролын үнэлгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дүн				7	312,464.5	4	265,161.5				3	47,303.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал												
1	Боловсролын үнэлгээний төв	АХГ-2022/34/НА-СТА-ТХН	Боловсролын үнэлгээний төвийн 2021 онд нийт 13,317.7 сая төгрөгийн 334 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 91.0 сая төгрөгийн 5 мэдээллийг ил тод байршуулаагүй, 1,762.2 сая төгрөгийн 32 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.	Өмнөх аудитаар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн боловч зөрчил дахин давтагдан гарсан тул хариуцсан албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага өгөх.	1				1		1	
Дүн				1				1		1		
Нийт дүн				8	312,464.5	4	265,161.5	1		1		3 47,303.0

